



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/485

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын дугуйн холбооноос зохион байгуулдаг "Монголын олон өдөр 2022" уралдааны санхүүгийн дэмжлэгт 3,000,000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 3,000,000 төгрөг (гурван сая)-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 4.3 дахь Спортын салбарын дэд хөтөлбөрүүд ("Дугуйтай Ховд") хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

Ховд аймгийн Засаг даргын 2022 оны
08 дугаар сарын 02-ны өдрийн
А/485 дугаар захирамжийн хавсралт



МОНГОЛЫН ДУГУЙН ХОЛБООНООС ЗОХИОН БАЙГУУЛДАГ
“МОНГОЛЫН ОЛОН ӨДӨР 2022” УРАЛДААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

| дд | Оролцох баг | Төсөв |
|----|--|-----------|
| 1 | Тэмцээн оролцох багуудад олгох дэмжлэг | 3000000 |
| | Дүн | 3,000,000 |

-oOo-